

ДОРНЫН СОНГОДОГ
ЗОХИОЛЫН ЦОМОРЛИГ

**ДАЙСНЫГ ХАШРААН ГЭСГЭЭСНИЙ
ЗОХИОЛ БӨГӨӨС ГУТГААР БӨЛӨГ:**

(Нийт ертөнцийн зохиол болой)

Д. Цэдэв

Бас Райчүн лам эрдэнэ, богд анхан үйл харыг (нүгэл) зохиосон гэж зарлигладаг ямар мэт нэгийг зохиосон бэ? гэж айлтгасан тул, хараал хийгээд мөндөр буулгаж хилэнцийг хураасан мөн гэж зарлиглав.

Богд хараал хийгээд мөндөр оруулахыг суралцахын чухалд авахын шалтгаан ямар мэт нэг гарсан гэж айлтгав. Би Митан гадха нэрт газарт уншлага суралцах цагт Зай гэдэг газрын адагт баясгалант хурим их нэг гарсан түүний суудлын голд багшийг урин залсаны бараа болоочоор би очсон. Тэнд архи элбэг хийгээд багшид тусгаар архи өргөөчин эрхэм олон гарснаас уусан тул согтууран одохуйд байсан. Багш надад хэрэглэ нигуудыг өгөх бөгөөд би түрүүлэн явсан тул, архинд согтох хийгээд энэ өдрийн дуу аялаачин (аваачин) бүхийд сэтгэл цацарсан аваас (хөөрсөнөөс) дуу аялах зүрхний угаас нэг гарсан буюу хоолой тэр өдөр цөлдөмхөн (цээлхэн) нэгэн байснаас дуу аялах бөгөөд явсан тул манай өөрийн байшингийн өмнө зам дээш буй тул үүдэн тушаа ирэхүйд дуу авсанаар ээжий, дотор будаа хуурч байснаа сонссоноос юу хэмээхүй дуу энэ миний хүүгийн дуу адил, бид эх хөвгүүн гуравт зовлон газрын дээр үгүй байтал дуу аялах (авах) буюу гэж бодсоноос сэтгэл давчдах байдлаар намайг мөн гэж мэдсэнээс гайхах бөгөөд, таягаа баруун талд орхиж, будааны хууруулыг зүүн талдаа хаяж будаа хуурсаны залгамжааг түлхүйд оруулж, баруун гартаа таяг нэгийг барьж, зүүн гарт үнс атга дүүрэн атгаж, урт шатаар буун богино шатаар дүүлсэнээс сөөргөө гүйн ирсэн болой. Үнс тэрийг нүүрэнд цацаж, таяг тэрээр толгойд хэднээ цохиод эцэг Милшаравжанцан чамд хүү энэ мэт төрсөн байна болой.

Чиний уг чинь тасрах байна. Бид эх охины үйлийг тухайд болгоох хийгээд ээжий түр нэгэн өнхөрөн өнхөрч байхын цагт, охин дүү ч гарч ирсэн болой.

Ажаа санаа сэтгэлээ ээжид тавил даа, хэмээх бөгөөд уйлахад үнэн, үнэн, би (Мил) өөрөө ч нулимс олныг алдав.

Бид охин дүү хоёр уйлахын агаараас ээжийн гарыг илэхчилэн түр нэгэн муширлаас сэргэх бөгөөд боссон тул уйлахын царайгаар намайг ширтэн ширтэн харсанаас хөвгүүн ямагт бидэн гурав шиг зовлонт газрын дээр үгүйд чи дуу аялах санаа чамд байдаг буюу.

Би хөгшин эхийн санаа бодол тавих нь бачимдах хийгээд уйлахаас л бус үгүй байна хэмээн шивших бөгөөд бидэн эх хөвгүүн гурвуулаа уйлсан болой.

Түүнээс би ээжий, ээжий үнэн бөгөөд, тэр төдийхөн зовоож бүү үйлдэе, би ээжий алин хүссэн үйл үйлдвэрийг үйлдэнэ буюу хэмээхэд, ээжий өгүүлрүүн: Би чамд хүрэм сайныг өмсгөөд, доор чинь морь сайныг унуулж дөрөө сайныг чийлгэвэл гайхал бүхний шилийг зад жийх тэр нэгийг хүсэх мөн бөгөөд, тэр өөрөө ямагт байхгүй адил буюу. Муу башир эрхэм байгаа мэт, буй тул хараал зүхэл, мөндөр гурвыг туйлд

нь хүргэх нэгийг суралцсанаас, авга ах, авга эгч тэргүүлж үйлдэхүй оронгын хүмүүн, айл сайрхаг, өвөр бидэн эх хөвгүүн гуравт зовлон тавиачин энэ бүхний язгуурын ёсон үндсээс угийг нь таслах нэгийг хүснэ болой.

Аяа, яахаа үз дээ хэмээхүйд би аяа яахаа ч үзнэ болой. Ээжий та ламын өргөл хийгээд миний замын хүнс завдалгаа нэгийг үйлдэх тул, ээжий хараал суралцахын хувь шалтгаанд тариалан Бриви (данчүн)-гийн талыг арилжсаны үнэнд оюу өнгө цацарсан нэрт нэг, морь хазааргүй цагаан арслан хэмээхүй орондоо баясгалант нэг, будаг хоёр богц, бурам хоёр богц хагас буйн бурам хоёр богцыг даруй хэрэгтэйд бэлтгэн завдлагааг төхөөрөх хийгээд Гунтан нэрт Лхүндүв донхон хэмээхүйд хэдэн өдөр сууснаас замын дэргэд нөхрийг эрсэн тул Ай Ри, Доло хэмээхүй газрын энхрий үзэсгэлэнт таван хөвгүүн Үй зангийн зүг дор ном хийгээд хараал суралцахаар яваа мөн хэмээн ирэх болой. Би бас хараал суралцахаар явах тул өвөр бидэн эвсэлдэх бөгөөс явъя хэмээсэнд болно хэмээв. Гунтангийн адагт хөтлөн хүрсэнээс хэдэн хоног бид хүндэтгэлийг үйлдэж тэр хүртэл ээжий тэд бүхэн надаас далдуур хөвгүүн энэ чин зориг байхгүй болой. Та нөхөд шаардлагын ташуураар хараал машид мэргэн нэгийг суралцаад ирэгтүн! Энд ирэхийн цагт бэлэг баясгалант үйл өгнө хэмээн үйлдсэн тул тэр цагаас моринд будаг хоёр богцийг ачаад, оюугаа биендээ хадгалж бид нарыг замд дор ээжий аглаг хол хүртэл дөхүүлэхэд хүрсэний замын завсарт, дөхүүлгийн архи уухуй газарт, ээжий миний нөхөд нарт захиа олныг үйлдэх бөгөөд байсан.

Ялгаамжтайн дээр намайг тусгаарлан гагцхүү ээжий хийгээд ганц хөвгүүн салан үл чадахуй, ээжий миний гараас барихад илэн илэн байх бөгөөд нүүрээр нулимс дүүрэн уйлан дуугаар ч хөвгүүн минь бидний үйлийг тухайд хар! Оронд хараалын шинж үзэгдэх нэгийг яав ч сурч ирэгтүн!

Тэд бүхний хараал бол хөвгүүн бидний хараалтай адилгүй болой. Тэд бүхэн энхрий балчир өөрийн баясландаа цатаархсаны хараал мөн дор байгаа. Хөвгүүн эх биднийх зовлон тулгарсаны хараал мөн тул чи чин зүрхнээс эгүүсгэх нэг мөн.

Хэрвээ хөвгүүн чи орон дор хараалын шинжийг үл үзүүлбээс буцаж ирэх хэрэггүй. Би хөгшин ээжий чинь чиний өөрийн өмнө боож үхнэ болой хэмээн тангаргалснаар бид эх хөвгүүн тус тус салан салсанаас би ээжийгээ сэтгэл цацран дурсах бөгөөд дахин дахин хойш эргэн харах хийгээд нулимс олныг алдав.

Ээжий ч ганц хөвгүүн надад сэтгэл цацрах тул бид нугуудын бараа тасрах хүртэл надаас нүдээ салгалгүй харан, харан уйлах бөгөөд явж байсан. Би ч ээжий лугаа адилхан нэгэн цацарч сөргөөн буцах буюу буцъя хэмээх сэтгэл машид үймрэх нэгэн гарсан болой.

Бид ээжийтэйгээ хожим үл учрах тэрийг сэтгэлээр мэдрэхүй мөн дор байв, эс үзэгдэх лүгээ ээжий орондоо уйлахуй бөгөөд буцаж ирсэн тул хэдэн өдрөөс Нянцайгаржангийн хөвгүүн хараал суралцахаар явсан байна, хэмээхүй их цуу гарсан байжээ.

Бид нугууд Үй зангийн замт яваад хүрсэл тул Зан, Рангийн (сарлагт) аймаг хэмээхүйд хүрэв. Орон тэр баялаг ихтэй нэг морь хийгээд будаг нугуудыг худалдаад үнэнд нь алт авснаас биенд зүүсэн бөгөөд Занбуу гэдэг газрыг арласнаас Үйг чиглэн хүрсэн тул Тон луг Райхай гэдэг газар хүрч (хонь, ямаа, үхэр хариулах) Үйн банди олон лугаа учирсан тэр. Тэд нугуудаас Үйн зугт болбоосуу, хараал, зүхэл, мөндөр гуравт мэргэн хэн хэмээх байгаа вэ? гэж асуусан тул банди нэгэн ийн өгүүлрүүн.

Ярлун жорво нэрт балгас хэмээхүйд лам Ягюндонто жил хэмээхүй байгаа бөгөөд тэр хараал зүхэл мөндөр тэргүүтэн хатуу тарни бүтээлийг олсон мөн бөгөөд, банди тэр өөрөө түүний шавь байсан гэв. Түүнээс бидэн нугууд лам Юндон тожил тэр ямагтыг чиглэн хүрсэн тул Ярлун жорвогын балгасанд хүрэв.

Лам лугаа уулзахын цагт тэр нөхөд нугууд ч мутрын өргөл элдэв зүйл нижгээд төдийхнөөс өөрийг үл тавив (өгөв). Би алт, оюу бүхнээ өргөсөн бөгөөд энээс гадна бие, хэл, сэтгэл гурвыг өргөвөө. Лам надаас оронгын хүмүүн айл сайрхаг жаргаланг булаасан хэтэрсэн байгаа байна, орон тэнд хараалын шинж гаргах хараалыг туйлд нь хүргэх нэгийг таалал нигүүслэхүйд ч барихыг айлтгах бөгөөд, завсрын хоол, хувцсыг ч таалал нигүүслэхүйд ч барихүйд дор айлтгалыг лавлан айлтгах тул айлтгасаныг Лам гэгээнээ (нүүрээ) мөшгөлзөх нэггэнг зохиож чиний үг тэрийг шинжин үйлдэнэ гэж зарлиглав. Түүнээс бидэн хараалыг туйлд нь хүртэл сурсан үгүй огторгуй, газрын ам хавсрах мэт эрэмгий чадалтай буй, муу тарни зүйл нижгээд төдийхөн, бас тус үйлдэх увидас гарын авах лугаа сэлтэст зүйл нижгээдийг хайрласнаас жил нэг төдий одох лугаа миний нөхөд бүхэн буцаж явахын завдалгааг хийж байцгаахад лам Үйн тэрмэн дээл сайн нижгээд бүхнийг оёулан хайрлаж байв.

Би сэтгэл нэг итгэмж үгүй бөгөөд, хараал тэдгээрийг орондоо шинжийг гаргах ч бэрхтэй байна. Хараалын шинж үл гаргаваас оронд (нутагт) буцахуй болохной ч ээжий амиа хорлон үхэх байгаа гэж бодоод завдалгааг эс үйлдэх тул, нөхөд нар өгүүллрүүн.

Тойвоогоо чи явахгүй юм уу хэмээцгээв. Би явахад хараалыг сураагүй хэмээвээс, тэд өгүүллрүүн:

— Өвөр бид ерөндөгийг дөхүүлэн чадсан увидас тэр бүхэн гүнзгий ямагт байна. Лам өөрөө ч тэрнээс илүү байхгүй гэж зарлиглаж байгаа тул бидэн хараалын горьдолгоо сэжгийг таслав.

Чи өөрөө, өөр байгаа мэт болбоос, ая хайрлахыг харалдаа хэмээцгээв. Тэд бүгдээр лам дор ажлыг үйлдэж гарын өргөл өргөн байхад би ч ламын хайрласан хувцас тэрийг өмсөөд тэд нөхдийг үдэхийн зам нэгийг хүртэл дөхүүлж, мах бодийн амгаланг эргэснээс тэд бүхэн орондоо буцаж одоцгоов.

Би ламын дэргэд буцаж ирэх замдаа, морь, илжигний баас, үхрийн баас, нохой сангарцаг нугуудыг түүх бөгөөд ирсэн тул хормой дүүрэнг олоод ламын зоогийн тариалан сайн ямагт байдаг тэрний захад газар малтах бөгөөс булав. Лам нойрсолгын байшингийн дэргэд байсан тул болгоох (харах) бөгөөд шавь хуврага олон л байсан, над урьд шавь хэдүй иймэрхүү нэгэн гараагүй бөгөөд энээс өөр халамжтай гарсангүй. Одоо ч байхгүй.

Тэр өнөөдөр миний (лагшин) мах бодийн амгаланг айлтгах үгүй байсан тэр ч буцаж ирэхийн шинж байжээ. Тэр анх миний газарт ирж байхын цагт ч надад оронгын хүмүүн айл гэрийнхэнд жаргаланг булаагдсан бид нэгэн байгаа тул, хараал хайрлахуйг айлтгая, бие, хэл сэтгэл гурваа өргөө хэмээхэд мунхаг энэ адил нэг байна гэж бодсон, тэрний үг хэр үнэн болмоожин хараал эс өгвөөс үү бас өрөвдөлтэй ч байгаа байна гэж зарлиглан шавь нэгээр надад хэлэх болмоожин, хараал тусгаар нэг зохистойд байгаа хэмээн баясгаснаас, ламын дэргэд хүрсэн тул, лам хараад Тойвгоо чи буцаж яваагүй юу мөн гэж зарлиглав.

Тэнд би ламын өөрийн хайрласан дээл тэрийг мутрын барьц болгоод мөргөж өргөв. Өлмийг оройгоор авах бөгөөд, лам их эрдэнээ! бид эх охин гуравт байгаа, авга ах, авга эгч эрхэмлэн үйлдэгч оронгын

айл гэрийнхэн хэдүй дайсанд боссон бөгөөд, хэлмэгдэх явдлаар авч элдэв зүйлийн үүднээс зовлон ямагтыг дэндээсэн тэрийг дахин дахин бусдыг эсэргүүцэхийн хүчингүй тул ээжий намайг хараал суралцахаар илгээсэн мөн.

Би хараалын шинж эс гаргахуй орондоо буцваас, миний өмнө ээжий гүжирдэж үхэх байгаа тул буцсангүй мөн. Тэрвээсүү, хараалыг туйлд нь хүртэл нэгийг хайрлахыг айлтгая хэмээн айлтгасан тул чамд оронгын хүмүүн зовлон ямар мэтийг тавьсан бэ? гэж зарлиглав.

Би эцэг Милширавжанцан бие таалал барьсаны ёсноос Авга ах хийгээд авга эгч зовлонг тавьсан, лам ч мэлмийгээ мэлмэрэн зохиосноос, тэр мэт үнэн болбоос, хэтэрхий зохисгүй байгаа тул, хараалыг би үйлдэж болох байна, шалдар булдарт үл татна, ер миний хараал энд Дод, Ай, Ри гурваас алт, оюу зууг өргөж, мянгаар өргөдөг. Мад, До, Хам гурваас хэв торго, цай хийгээд хоргой магнаг зуугаар өргөж мянгаар өргөдөг. Завсарт Үй, Зан, Рү дөрвөөс цэмбэ, тэрэм хийгээд тос, будаа зууг өргөж мянгаар өргөдөг. Жа, Даг, Гон гурваас хайнаг, морь хийгээд сарлаг, хонь зуугаар өргөж мянгыг өргөдөг байсан бөгөөд бие, хэл, сэтгэл гурваа өргөө хэмээхүй чамаас бус үл гарсан байгаа хүмүүн чиний үг тэрийг Шинжин түргэн нэгийг (хараал) үйлдэнэ гэж зарлигласан болой. Тэр цагт лам дор шавь, их заанаас хүчтэй нэг байсан тэрийг миний оронд харахаар илгээсэн тул тэр өтөр түргэн очоод ирсэн бөгөөс лам их эрдэнээ! Тойвгоогийн хэлдэг үнэн байгаа тул хараалыг машид хайрлах хэрэгтэй ямагт зохистой гэж айлтгах бөгөөс байсанд, ламын гэгээнээс анханаас шалдар булдарт хараал өгвөөсүү мунхаг чи цөвтөж үйлдэхүй байгаа мөн.

Одоо үнэн байгаа учир хараал өгнө, хараал суралцахад бусад нэгэн явах хэрэгтэй, надад хараал салан марнаг хэмээхүй хум гэхэд үхэхүй, пад гэхэд муужран унахуй байгаа тэрийг Зан Ронгийн Нүбхүлүн ба хэмээхүйд болбоосу лам Хулун ёндонжамц хэмээх эмийг ч барьдаг тарнид ч мэргэн нэгэн байгаа түүнд өгнө. Тэр мөндөрийг долоовор хуруугаар гаргах нэгэн байгаа тэр надад зааж өгсөн байгаа, бидэн хоёр зохиолдуу нөхрийг үйлдэх бөгөөд надад хараал суралцахаар ирсэн бүгдийг над руу илгээн үйлдэх тул тэрүүнд мөндөр суралцахаар ирсэн бүгдийг над илгээх буюу үйлдэх мөний тул тэрвээсүү чи ч тэрний дэргэд эдүгээ миний хүү энэ лүгээ ханилан явах мөн гэж зарлиглав.

Миний өөрийн их хүү Дармааванчиг хэмээхүй хийгээд та хоёрт хүнс зэхэн Үйн цэмбэ, тэрэм нийлэлдсэн хайнагийн шарын ачаа нэг хийгээд мутрын тэмдэг шүтээн лүгээ сэлтэстийг хайрласнаас Зан Ронгийн Нүбхүлүн ёндонжамц-д хүрсэн тул лугаа уулзсан болой.

Цэмбэ боодол нижгээд мутрын харамж хийгээд ламын мутрын тэмдэг шүтээн лугаа сэлтэстийг өргөөд лам дор ч учир шалтгаан түүхийг нягтлахыг айлтгах бөгөөс хараалыг таалалдаа асаах айлтгалыг айлтгав.

Ламын гэгээнээс, миний нөхрийн шижим урт, үг лавтай сүүл нь баттай, та хоёрт тэр хараалын увидас яав ч өгөх мөний тул уулын хамарт гарын хүчээр сүйтгэхээргүй бүтээлийн байшин барь гэж зарлиглав.

Тэр дороо ташир гурван өрөө буй, дээрээ зэргэлдээ ганц өрөө нуруу сайн дөрвийг суурь тавь, гадна талаар бул чулуу сарлагийн хүүр төдийхнээр завсаргүй тавьсанаас бүтээлийн байшингийн үүдийг бусад эс эвдэх хийгээд гарын хүчээр сүйтгэгдэхгүйг барьсан тэрээр хараалын увидасыг хайрлах бөгөөс хараал бүтээхүй хоног долоо одох лугаа

лам залран ирээд урьд мөн болбоосуу, хоног долоо нижгээдэд болдог буй.

Эдүгээ ч лавтай болсон байх гэж зарлигласанд би бүглэг холын хараалч мөний тул эдүгээ ч хоног долоо бүтээхүйд айлтгалыг айлтгасан тул болбоос бүтээнэ нэгийг гэж, тэгэвч зарлиглан бүтээх тул хоног арван дөрөв одохын шөнө (хараал бүтсэн) болой. Лам залран ирсэн бөгөөд тэр шөнө хот мандалын захаар хараалын шинж байгаа байна гэж тэр зарлиглав.

Энэ шөнө зарлигийн сахиус тангарагтан хүмүүн толгойтой гучин тавын цул зүрх лугаа сэлтэстийг улбалзуулсаар авчирсан дор хаяснаас (өчигдрөөс) биднийг авар гэж биднийг дуудах бөгөөд шаардах тэр, энэ хэрэгтэй мөн байна хэмээгээд хот мандалын захаар овоолон одсон.

Маргаар (маргааш) ч лам залран ирснээс эдүгээ гэтэлгэх учиртай хоёр байна.

— Гэтэлгэх үү? агуулахуй гэж зарлиглав. Тэр би бах хийгээд тавалгаа ханасаны шүтээнд агуулъя гэж айлтгалыг айлтгасанаас тавалгаагаар авга ах, авга эгч үйлдсэн байв. Тэнд Дамжин Чойжин тангарагтан, номын тэтгээчин нигуудад зан үйлийн ажил үйлдэж, өргөснөөр (Бясалгалын цаазаас) тайлагдаж Хүлэнд болбоосуу, эдүгээ ч бүтээлийн байшингийн туурь байгаа буй.

Тэр цагт миний орон Жан ри зайд хараалын шинж хир адил нэгэн гарсан хэмээвээсүү?

— Авга ахын ах хүү гэргий таалсаны гэргийн хуримын газарт, авга ахын хөвгүүн хийгээд гэргийт тэргүүлэн эх хөвгүүн бидэнд машид өстэй хүмүүн эрхшээсэн гучин тав бүрдсэн байв. Зочид бусад хий гээд бидэнд сайн хүмүүн ирэхийн шахамд замын завсар өгүүлрүүн:

— «Эзэн бус эзэнд горилж, эзэн нь үүдэн нохойд гарна» хэмээх үг үлгэр мэт үйлдээчний сэтгэл зовдоггүй энэ бүхэнд Тойвоогийн хараал үл ирэх болохной ч чухаг дээдийн үнэн хараал нэг ирэх зохистойд хэлэлцэхийн цагт багталцах төдийн завсар тэнд авга ах, авга эгч хоёр хүмүүнд идээ энийг өг, хариуд энийг буцааж өгнө гэж зөвшөө үйлдэх бөгөөд сөргөө суухын цагт урьд бидэн өөрийн зарц эм, хожим авга ахын зарц болгосон нэг ус авахаар явсан хүүрэнд болбоосуу, морь, олон уяатай буйг эс харагдах завсар аалз, могой, мэлхий тэргүүлэн дүүрсэний дотор эвэрт хилэнцтэн хорхой (хавч) адил сарлаг төдийхөн нэг, эврээ баганын завсар хийсэн бөгөөд гадагш ольж байгаа үзэгдсэн тул айх нь дэндэж уйлах бөгөөд агадагш харсан даруйд, хүүрэнд болбоосуу, морь, гүү олон нийлэлдэж уяатай байснаас азрага гүүг хассанаар морьд хаслан өшиглөлдөх хийгээд тэрбээр азарганд хаслан өшиглөсөн нь баганад туссан тул багана хугарах бөгөөс байшин цөмөрч доор нь авга ах хийгээд бэр тэргүүлэн хүмүүн эрхшээсэн гучин тав үхэхсэнд байшингийн дотор шороо бужигнан хүүрээр дүүрэв. Гадна уйлан цурхираан дүүрсэн тэрийг Вида (миний охин дүү) үзсэн бөгөөд өтөр даруй ээжийн газар хүрч, ээжий, ээжий авга ахын байшин цөмөрсөнөөс хүмүүн гучин тав үхсэн байгааг харалдаа! хэмээх үгийг өгүүлсэнд, ээжий үнэн болбуу, худал биш биз, хэмээн баясах нь дэндээд босох бөгөөд харсан тул, авга ахын байшин шороо, ус үймэртэж гадаа уйлаан гиншлэгээн гарах бөгөөс гайхсан мэт баяссанаас тэр цагт ээжий таяг урт нэгний үзүүрт дээлийн тамтархай өлгөн хийсгэж өндөр дуугаар соёрх, тахигтун, бурхан лам чухаг дээд гурав, тэд оронгын хүмүүн айл гэрийнхэн сайрхаг бүхэн Милшаравжан цанд хөвгүүн төрсөн ая байна. Эдүгээ Нянцай гаржан дээл навтархайг өмсөж, хоол мууг идсэн хөвгүүний хүнсийг бэлдсэнд тус гарсан

«аяа» байгааг харах хийгээд, авга ах, авга эгч хоёр болбоосуу өгүүлрүүн: «Тэд олон болбоосуу цэрэг тат! цөөн болбоосуу хараал гарга!» хэмээн үйлдсэн болой. Одоо цөөнийн хараал тавьсан олны цэрэг татсанаас үлэмж нэг гарсан, тэрийг дээр хүмүүн дор хар, доод мал дор хар, завсарт эд дор хар, доод мал дор хар, ер хүмүүн үхэлгүй урт наслахын цагт хөвгүүний үзүүлсэн сонин явдал энэ адил гаргахын цаг ирсэн мөн.

Би Нянцагаржан дор эдүгээс янз баясгалан ая байгааг хар хэмээв. Бахархах хийгээд тавалгаа ханахуй дор гэрт үл багтсан бүхэн сонссон тул зарим зарим өгүүлэх нь:

- Эмийн зөв, үйлдэх зохистой хэмээв. Зарим, зарим өгүүлрүүн, зөв ч, зөв бөгөөд эдүгээ хэтэрхий дэндэв хэмээв.

Тэрний хүчээр хүмүүнээ үхүүлсэн бүхэн сонссоноос цуглах бөгөөд эм эдүгээгийн гутамшиг их энийг хөдөлгөөд бас болдоггүй тавалгаа бахархан тэрийг үйлдэх нь хэрцэл дэндэж зовлон ёсон зүйлийг тавьсаны амаар нь зүрхийг улвалзуулан гаргаж үйлдэнэ хэмээхүйд хөгшид зарим өгүүлрүүн:

Эмийг алаад тус юу болох вэ- бас өвөр бидэн бүхэнд эмийн хөвгүүн энэ адил нэгийг ирүүлэх тэр болно амайц.

Тэр анханд эмийн хөвгүүнийг эрэх бөгөөд гарын хүчээр алах юу чадахаа бодох, тэр эм өөрийг алах ёс хялбар хэмээсэнд ам таацалдав, авга ах сонссон тул эдүгээ хөвгүүн үхэхийн учир хийгээд охин үхэхийн учиргүй эдүгээ би үхвээсүү баярлана хэмээн, ээжийг алахыг зэхсэнд, оронгын хүмүүн зарим хориглох бөгөөд саяын ч чиний хэт дээрэлхсэний уршгаар энд гутамшиг энэ гаргасан мөн.

Эдүгээ ч эмийн хөвгүүнийг эс албаас үйл энийг үйлдвээсүү, өвөр бидэн бүхнийг бүрэлгэн үйлдэх тул авга ахын үйлдэх арга гарсангүйд үлдэв.

Тэрээс оронгын хүмүүн заримыг намайг алахаар илгээхийн зөвшөөлийг үйлдсэн тул, нагац, ээжий газарт ирээд төлдөр (өчигдөр) үг тэр хийгээд үйлдэх авир ёс тэрээр эдүгээ оронгын хүмүүн нугууд чамайг өөрий чинь хийгээд хөвгүүнийг гарын хүчээр алах гэж байгаа буюу, чадал өөрт чинь юу байна вэ? хараал гарсан ямагтаар болох биз, хэмээн олонтой жил зэмлэхүйд, ээжий нагацыг өврийн чинь дээр үл ирсэн мөн.

Тэр төдийхөн нэг болбол надад ч байх тэр, миний эд бүхэн тэрийг булаан авч үйлдсэн ёс, тэрийг үйлдсэн тэсэхэд бэрхтэй тэр л байна, хэмээн хариу бусдыг үл өгүүлэн уйлсан тул, нагац ч үнэн та хоёрын л үнэн, эдүгээ алаачин гарсан байгаа тул үүдээ бат байлга хэмээн гарч одов.

Сүүлд үүдээ чандалсны агаараас санаа бодол элдэвд тавих бөгөөд байхын үесд, авга ахын боол эм, урьд бидний өөрийн боол мөн тэр, тэд бүхний зөвшөөл үйлдсэнийг сонсоод эмийн яс халамцуулсанг тэсэшгүйд ээжид тэд бүхэн зөвшөөл энэ мэтийг үйлдэх бөгөөд байгаа тул хөвгүүний амийг сэрэмжлэн зохиогтүн! хэмээн өгүүлсэн тул ээжий санаа, тэд бүхэн зөвшөөл биднийг алахгүй тул сэтгэлийн тайвшрал гарав хэмээв, хэмээгээд тариалан (Брэвдончүнгийн хагасыг худалдсаны үнэнд алт долоон цэнг аваад оронгын хүмүүнийг илгээх болохгүй, бусад яруу элч учрах үгүй тул, ээжий өөрөө надтай учрах хийгээд хүнсийг дөхүүлэх ба аман захиа одуулах байгаа хэмээхийн цагт Үйн зүгийн егүзэр Балбад мөргөлөөр яваад буцаж яваа нэгэн бадарчин явах дор ирсэн. Тэр байдлыг нягтлан асууж яруу элч зохистой байгаа бөгөөд, хоног хэдүй энд саатан Үйн зүгт миний ганц хүү байгаа тул, тэрүүнд захиа нижгээд төдийхөн өгөхүй мөн тулд тэр

нугуудыг ч учруулах нөхрийг үйлдээд, тэр завсар өлмийн (хүндлэл) үйлдэн жаргалангийн мэдэрлэг үйлдсэн тулд ээжийг зул нэгийг асаах бөгөөд миний санаа сэтгэлчилэнх бүтэх болбоос, зул энэ өнө удаан орших хийгээд, эс бүтэх болоосуу түргэн жаргахын (мөхөх) үйлсийг Тойвоогийн лам хийгээд Чойжин (номын тэтгээчин) өгүүлэх нэгийг үйлдсэн шившлэгийг орхив. Зул хоног нэг бүтэн нэг ассан бөгөөд, сэтгэл бүтэхүйд дор итгэмжлэсэнээс егүзэр хан гүрэн эргэсний дээл, гутал хэрэг ихтэйд нөхөөс хийгээд улалгааг учруулан еэр улалгааны үргэлжлэл нугуудыг тэр өөрт тушаагаад дээлийн хэвнэг нэг байсан тэрийг ээжийг ч өөрөө нөхөөсийг тавив. Хэмнэгийн дотор ар голд егүзэрт мэдэгдэхээргүй алт долоон цэнг нуув.

Түүний дээр нөхөөс хар ам нэг дөрвөлжин нэгийг тавьж, голд утас бүдүүн цагаан еэр утсаар шаггаж оёод, зургаан мичид маралын одны хэлбэр адил гадна талд нэг дарсан (хатгаж) бөгөөд егүзэрт ч шан их нэгийг өгөөд захиаг нууцлан тамгаар баталсан байгаа нэгийг өгөөд ийн өгүүлсэн болой.

Тэрнээс ээжийг санаа бодолд оронгын хүмүүн энэ заримуудын зөвшөөл үйлдэх ёс энэ юу үйлдсэнг эс мэдэх тул ёслох нэгнийг үйлдэе хэмээн, Бидаад (охин дүүгийн нэр) зааж өгөөд төлдөрийн егүзэр ахаас (Тойвгоо) захиа өгсөнийг авчирав, хэмээн бүхэнд дуурсган тараав.

Ээжийг намайг өгүүлсэн мэт үйлдэж захиад, ээжийг хийгээд охин дүүгийн мах боди амгаланг асууж, хараалын шинж гарсан ихтэй, эдүгээ оронгын хүмүүн та эх, дүүд ялангуяа занал үйлдсэн хүмүүн гарбаасуу, нэр, ясыг захианд бичээд явуул! би хараалд шүтсэнээс хүний амийг таслах гурилаар хийсэн тахилаас хялбар байгаа тул есөн удам үндсийг нь таслах болно. Оронд тэд ямагт занал үйлдвэл эх, дүү миний зүгт ирэгтүн!

Би орон тэрийг гарах мөр үгүй нэгийг үйлдэж урлах мөн. Эдүгээ төгс эдлэл хийгээд амьжиргаа түрвэхгүйн агаараас бүтэж үйлдэх бөгөөд байгаа тул миний төлөө санаа бүү зовоо! хэмээхүй нэгийг зохиож бичээд тамгалж үйлдэх бөгөөд анханд нагац тэргүүлэн бидэн өвөрт сайн хүмүүн заримд үзүүлэв.

Тэрээс бичгийг нагацын гарт хүргэсэнээс бүхэн сонсож, үйлдсэн тул, тэд зарим урвах болсон бөгөөд гарын хүчээр санаа найруулгыг орхисоноор тариалан Брэйданчүн нэртийг ч авга ахын гараас авах бөгөөд, ээжид эгүүлэн өгөв. Егүзэр тэр ч намайг эрэн сурах бөгөөд ирсэн тул намайг Нүбхүлүнд байгаа хэмээхүй сонссоноос миний газарт ирсэн бөгөөд, ээжийг хийгээд охин дүү тэргүүлж оронгын учир түүх нугуудыг дэлгэр өгүүлээд, захиа учруулан тусгаар нэгийг уншсанд Тойвоогийн мах боди сайн байгаа биз? хөгшин эх дор хөвгүүн төрсөний санаа бүтээлээ. Эцэг Милшаравжанцангийн угийг барив.

(Түрүүч нь 1991 оны № 1-т
Үргэлжлэл бий)